



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: contact@ub-procurement.mn  
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.10.16 № 03/1966

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулга оруулах тухай

Тус газраас зарласан НХААГ/20240101236 дугаартай Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн бүтээн байгуулалтын ажлын тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шатны тендерийн баримт бичигтэй холбоотой сонирхогч этгээдээс тодруулга хүссэнтэй холбогдуулан дараах тодруулгын хариуг хүргүүлж байна.

№	Оролцогчийн тодруулга	Захиалагчийн тодруулгын хариу
1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн 13.2.6-д санал болгож буй ажил нь ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг тендерийн иж бүрдэлд ирүүлнэ гэж заасан боловч тендерийн баримт бичгийн II бүлэг, өгөгдлийн хүснэгтэд ТШЗ 20 дахь заалт байхгүй байна.	Тус нээлттэй тендер шалгаруулалт нь 2 үе шаттай зохион байгуулагдаж байгаа бөгөөд нэгдүгээр үе шатанд оролцогчид зөвхөн тендерийн баримт бичгийн II бүлэгт оруулсан өгөгдлийн хүснэгтийн дагуу материал ирүүлнэ. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааг (ТШЗ) бүрэн эхээр нь хоёрдугаар шатны нээлттэй тендер шалгаруулалтад оруулна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.